



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2-ийн 2.2.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах журмыг нэгдүгээр, "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулах ажилтны тодорхойлолтыг хоёрдугаар, "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгийн үнэмлэхний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 47 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг төрийн бүх байгууллагуудад хүргүүлэн танилцуулж, хэрэгжүүлэхийг Ажлын албаны дарга (С.Цэдэндамба)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЦОГОО

“ТӨРИЙН АЛБАНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” тэмдгээр шагнах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн албаны чиг үүрэг, хуулиар хүлээсэн үүргээ үнэнч, шударгаар биелүүлж төрийн албанд олон жил тогтвортой, мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллаж амжилт гарган ажилласан төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан төрийн албан хаагчийг Төрийн албаны зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн “ТӨРИЙН АЛБАНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” тэмдгээр шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагнал олгох болзол

2.1. Шагналд тодорхойлсон төрийн албан хаагч дор дурдсан болзол хангасан байна. Үүнд:

2.1.1. Төрийн албанд 18-аас доошгүй жил ажилласан, ажил мэргэжлээрээ тухайн салбарын тэргүүний амжилтны болзол ханган амжилт үзүүлсэн, мэргэжлийн өндөр ур чадвар гарган эрхэлсэн ажилдаа өндөр амжилт үзүүлж сүүлийн 5 жилд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр “А”, “В” үнэлэгдсэн байх;

2.1.2. Төрийн байгууллагын зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан ба төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд шинэлэг арга ажиллагаа нэвтрүүлсэн байх;

2.1.3. Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайллын хувьд үлгэр жишээ ажиллаж, ашиг сонирхолын болон ёс зүйн аливаа зөрчил гаргаагүй байх;

Гурав. Шагналд тодорхойлох

3.1. Энэхүү журмын 2.1-д заасан болзлыг хангасан гэж үзсэн төрийн албан хаагчийн тодорхойлолтыг дараахь байгууллага, албан тушаалтан Зөвлөлд уламжилна. Үүнд:

3.1.1. Яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь яамны болон харьяа Засгийн газрын агентлаг, харьяа байгууллагын албан хаагчийн;

3.1.2. Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга болон төрийн бусад албан хаагчийн;

3.1.3. УИХ-ын Байнгын хороо нь УИХ-ын гишүүний;

3.1.4. Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Ерөнхийлөгчийн зөвлөх, Тамгын газрын ажилтны;

3.1.5. УИХ-ын Тамгын газар нь УИХ-ын даргын зөвлөх, ажлын албаны болон Тамгын газрын албан хаагчийн;

3.1.6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Тэргүүн шадар сайд, Шадар сайд, тэдгээрийн зөвлөх, ажлын албаны болон аймаг, төрийн бусад албан хаагчийн;

3.1.7. Төсвийн Ерөнхийлөн захирагч нь УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын албан хаагчийн;

3.1.8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь бүх шатны шүүгч, шүүхийн байгууллагын албан хаагчийн;

3.1.9. Улсын Ерөнхий прокурор нь бүх шатны прокурор, прокурорын байгууллагын албан хаагчийн;

3.1.10.Төрийн албаны зөвлөлийн дарга нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, Зөвлөлийн бүтцийн нэгжийн албан хаагчийн;

3.1.11.Төрийн албаны зөвлөл нь өөрийн санаачилгаар нэр дэвшүүлсэн албан хаагчийг тус тус тодорхойлно.

3.2. Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь төрийн албан хаагчийг уг шагналд тодорхойлохдоо Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрийг зохих журмын дагуу албажуулж холбогдох баримт бичгийн хамт ирүүлнэ.

3.3. Шагналд тодорхойлсон төрийн албан хаагчийн талаарх баримт бичиг, саналыг Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг судлан үзэж дүгнэлт гаргаж Зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ. Зөвлөл "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай тогтоол гаргана.

3.4. Зөвлөл Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг жил бүр шинэчлэн тогтооно.

3.5. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгийг улсын тэмдэглэлт ой, зайлшгүй шагнах шаардлагатай үед тухай бүр, бусад үед хагас жилд нэг удаа хэлэлцэж Зөвлөл зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

3.6. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгийг энэхүү журамд заасан санал, тодорхойлолт гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан ёслол хүндэтгэлтэйгээр гардуулна.

3.7. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн баримт бичгийг буцааж олгохгүй ба Төрийн албаны зөвлөлийн архивт хадгалагдан үлдэнэ.

Дөрөв. Шагналын баталгаа, дагалдах мөнгөн шагнал

4.1. "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгийн үнэмлэхэд Төрийн албаны зөвлөлийн дарга гарын үсэг зурах бөгөөд тамга дарж баталгаажуулсан байна.

4.2. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнагдсан төрийн албан хаагчид тухайн байгууллага нь 200.000 /хоёр зуун мянган/ төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгоно.

Тав. Шагнуулах ажилтан, албан хаагчдын баримт бичгийн бүрдүүлэлт

5.1. Шагналд өргөн мэдүүлсэн хүний анкет;

5.2. Ажил байдлын тодорхойлолт (Шагнуулах үндэслэл);

5.3. Салбар зөвлөлийн болон тухайн байгууллагын хамт олноор хэлэлцүүлсэн тогтоол, санал, хурлын тэмдэглэл;

5.4. Салбар зөвлөлгүй Төрийн улс төрийн болон үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн хувьд түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг үндэслэн шийдвэрлэнэ.

5.5. Баримт бичгийг ирүүлэхдээ батлагдсан маягыг бөглөж хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарын хамт ирүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан иргэнд "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах саналыг түүний ажиллаж байсан төрийн байгууллага болон Салбар зөвлөл Төрийн албаны зөвлөлд гаргаж болно. Энэ тохиолдолд энэхүү журамд заасан баримт бичгийг санал гаргасан тал бүрдүүлж Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ.

6.2. Энэхүү журамд заасан болзол болон баримт бичгийн шаардлага хангаагүй материалыг Төрийн албаны зөвлөл буцаана.

___ оОо ___

**“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр
шагнуулах ажилтны тодорхойлолт**

20... оны ... дугаар сарын ... өдөр

1. Овог, нэр
2. Ургийн овог
3. Хүйс
4. Төрсөн он
5. Регистрийн дугаар
6. Төрсөн газар
7. Үндсэн захиргаа
8. Албан тушаалын ангилал зэрэглэл, зэрэг дэв
9. Боловсролын талаар (ерөнхий, тусгай дунд, дээд боловсрол, дипломын, бакалаврын болон магистрийн зэргийг оролцуулна)-х мэдээлэл



Зураг 3x4

Сургуулийн нэр	Орсон он, сар	Төгссөн он, сар	Эзэмшсэн боловсрол, мэргэжил, гэрчилгээ, дипломын дугаар

10. Туршлагын талаарх мэдээлэл.

Улсад ажилласан нийт жил:

Үүнээс: Төрийн албанд

-Төрийн улс төрийн албан тушаалд

-Төрийн захиргааны албан тушаалд

-Төрийн тусгай албан тушаалд

-Төрийн үйлчилгээний албан тушаалд

Хувийн хэвшилд

Хөдөлмөр эрхлэлтийн байдал:

Ажилласан байгууллага, газар, түүний хэлтэс	Албан тушаалын нэр	Ажилд орсон он, сар	Ажлаас гарсан он, сар

11. Төр, Засгийн ямар шагналаар хэзээ шагнагдсан.

Шагналын нэр	Зарлиг, захирамж, тушаалын нэр, он, сар, өдөр, дугаар	Үнэмлэхний дугаар	Шагнал олгосон үндэслэл, тайлбар

12. Бусад ямар төрлийн шагналаар шагнагдсан.

.....
.....
.....
.....
.....

13. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчлийн талаар.

.....
.....
.....
.....
.....

14. Байгууллага, хамт олны хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэл.


.....
.....
.....
.....
.....

15. Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнагдах үндэслэл, тайлбар.


.....
.....
.....
.....
.....

..... / /
(албан тушаал) (гарын үсэг)
Тэмдэг
(огноо)


“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгийн үнэмлэхний загвар



14.5 см



9.5 см



Үнэмлэхний дугаар

.....танаа

Төрийн албаны чиг, үүргийг үнэнч шударга, идэвх санаачилгатай биелүүлж, төрийн үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсныг өндрөөр үнэлж Төрийн албаны зөвлөлийн 20..... оны дугаар тогтоолоор “ТӨРИЙН АЛБАНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” тэмдгээр шагнав

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга

Б.ЦОГОО

20..... оны сарынөдөр

7.25 см